



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020.08.  
2020.08.



## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар .....	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага .....	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр .....	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй .....	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
  - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
  - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

  - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
  - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
  - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
  - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
  - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
  - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

**Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

**Борлуулсан бүтээгдэхүүн** нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл** нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



## ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

### ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС

			Үүнээс	Үүнээс
			Эм	Эр
Баянхонгор	Баацагаан сум	1 058	198	860
Баянхонгор	Баянбулаг сум	494	83	411
Баянхонгор	Баянговь сум	887	210	677
Баянхонгор	Баянлиг сум	1 075	211	864
Баянхонгор	Баян-Овоо сум	853	190	663
Баянхонгор	Баян-Өндөр сум	744	146	598
Баянхонгор	Баянхонгор сум	9 633	3 417	6 216
Баянхонгор	Баянцагаан сум	1 036	218	818
Баянхонгор	Богд сум	900	187	713
Баянхонгор	Бөмбөгөр сум	1 015	210	805
Баянхонгор	Бууцагаан сум	1 090	230	860
Баянхонгор	Галуут сум	1 253	238	1 015
Баянхонгор	Гурванбулаг сум	653	100	553
Баянхонгор	Жаргалант сум	905	209	696
Баянхонгор	Жинст сум	644	115	529
Баянхонгор	Заг сум	633	123	510
Баянхонгор	Өлзийт сум	1 147	250	897
Баянхонгор	Хүрээмарал сум	528	86	442
Баянхонгор	Шинэжинст сум	768	170	598
Баянхонгор	Эрдэнэцогт сум	1 297	271	1 026
<b>Нийт</b>		<b>26 613</b>	<b>6 862</b>	<b>19 751</b>

## ХҮН АМЫН ТОО

Засаг захиргааны нэгж	2019			2018		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Баянхонгор	89,253	43,974	45,279	88,359	43,530	44,829
Баянхонгор	32,297	15,399	16,898	31,685	15,127	16,558
Баацагаан	3,282	1,673	1,609	3,307	1,679	1,628
Баянбулаг	1,789	878	911	1,767	877	890
Баянговь	2,986	1,438	1,548	2,922	1,420	1,502
Баянлиг	3,860	1,906	1,954	3,848	1,906	1,942
Баян-Овоо	2,594	1,353	1,241	2,650	1,384	1,266
Баян-Өндөр	2,650	1,342	1,308	2,668	1,350	1,318
Баянцагаан	3,592	1,809	1,783	3,590	1,811	1,779
Богд	3,127	1,541	1,586	3,113	1,516	1,597
Бөмбөгөр	3,323	1,675	1,648	3,288	1,644	1,644
Бууцагаан	3,703	1,858	1,845	3,670	1,836	1,834
Галуут	4,112	2,138	1,974	4,103	2,122	1,981
Гурванбулаг	2,273	1,128	1,145	2,216	1,096	1,120
Жаргалант	2,901	1,443	1,458	2,961	1,474	1,487
Жинст	2,228	1,104	1,124	2,192	1,084	1,108
Заг	2,086	1,064	1,022	2,073	1,050	1,023
Өлзийт	3,845	1,926	1,919	3,870	1,945	1,925
Хүрээмарал	1,793	908	885	1,748	883	865
Шинэжинст	2,493	1,230	1,263	2,449	1,205	1,244
Эрдэнэцогт	4,319	2,161	2,158	4,239	2,121	2,118



### ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2020 оны 08 дугаар сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 9843.2 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 269.1 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. 2020 оны 08 дугаар сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Богд, Хүрээмарал, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан, Баянговь, Гурванбулаг, Жаргалант, Бөмбөгөр, Баянбулаг, Жинст, Галуут, Эрдэнэцогт, БаянОвоо, Өлзийт, сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: хог хаягдлын хураамж 32.3 сая төгрөг, АТӨЯХ-ийн татвар 36.5 сая төгрөг, ус бохирдуулсаны төлбөр 1.2 сая төгрөг, НӨАТатвар 134.3 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 116.4 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 123.9 сая төгрөг, Орон нутгийн зам ашигласны хураамж 10.1 сая төгрөгөөр тус тус тасарч, ЦХТА орлого /суутган-1/ 457.3 сая төгрөг, агаарын бохирдол (авто) 10.3 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 16.7 сая төгрөг, ус ашигласны төлбөр 214.5 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 3.1 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.5 хувь, ЦХТА орлого 41.2 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 4.7 хувь, хүү торгууль 8.6 хувь. бусад төлбөр хураамж 15.8 хувийг тус тус эзэлж байна



## МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 08 дугаар сарын 31-ны байдлаар арилжааны банкуудаар нийт зээлийн үлдэгдэл 194836.5 сая төгрөг байгаагийн 3249.2 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 3075.7 сая нь чанаргүй зээл байна.

2020 оны эхний 8 сарын байдлаар нийт хадгаламжийн үлдэгдэл 140781.2 сая төгрөг болжээ. Үүний 40953.4 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 99827.8 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

31/08/2020

(Мянган төгрөг,  
тоогоор)

Үзүүлэлт		Үлдэгдэл
<b>Зээл</b>	<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>194,836,536.6</b>
	Үүнээс:	
	<i>Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл</i>	3,249,240.8
	<i>Чанаргүй зээлийн үлдэгдэл</i>	3,075,656.8
<b>Татан төвлөрүүлсэн хөрөнгө</b>	<b>Нийт харилцахын үлдэгдэл</b>	<b>23,293,254.2</b>
	Үүнээс:	
	<i>Иргэдийн харилцахын үлдэгдэл</i>	18,203,024.1
	<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>140,781,175.5</b>
	Үүнээс:	
	<i>Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл</i>	136,188,854.8
	<i>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</i>	40,953,368.3
	<i>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</i>	99,827,807.2
<b>Тоон мэдээлэл</b>	<b>Нийт банкны салбар, нэгжийн тоо</b>	54
	<b>Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо</b>	249
	<b>Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)</b>	40057
	<b>Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)</b>	139044
	<b>Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)</b>	74353
	<b>Нийт АТМ-ны тоо</b>	33
	<b>Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо</b>	66055



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 8 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 2.2 хувиар буурчээ, ийнхүү буурхад голлож хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас бөс бараа, орон сууц, орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ бүлгийн бараа бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ буурсан нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.6 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, хувцас бөс бараа, орон сууц, орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ бүлгийн бараа бүтээгдэхүүний бүлгийн барааний үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 08 дугаар сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 3.3 хувиар өссөн байгаа нь голлож хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

### ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Барааны бүлгээр	2020.08	2020.08	2020.08
	2019.08	2019.12	2020.07
ЕРӨНХИЙ ИНДЕКС	103.3	102.6	97.8
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	104.7	106.0	92.0
СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	105.6	104.0	100.0
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	101.7	100.4	100.0
ТАМХИ	100.6	100.0	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	108.2	105.1	100.3
ГУТАЛ	110.0	106.1	100.5
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД	99.2	99.2	100.1
ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	97.3	97.3	100.4
УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	100.0	100.0	100.0
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	104.8	104.0	100.9
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	106.1	104.9	101.5
ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	101.9	101.9	100.0
ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	102.2	102.2	100.0
ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	113.0	108.0	105.3
ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	105.0	105.0	100.0
ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА, ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.3	103.1	100.0
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.5	102.5	100.0
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	103.3	103.3	100.0
АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ТЭЭВЭР	95.7	95.0	101.0
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	102.7	102.7	100.0
ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	88.4	87.2	102.3
ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.2	101.2	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.2	100.2	100.0
АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	103.3	102.9	102.9
ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	100.0	100.0	100.0
ЧӨЛӨӨТ ЦАГ СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
НОМ СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	108.4	107.4	107.4
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЗОЧИД БУУДАЛ НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	102.3	102.3	100.0
БУСАД БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	104.9	102.9	98.8
ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	104.9	103.1	98.1
ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	106.6	102.9	102.9
САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал тооллогын дүнгээр 2019 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн тоо 4644.8 мянга болж, 2018 оныхоос 9.3 хувь буюу 395.3 мянган толгойгоор өссөн байна. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо 189.5 мянга, үхэр сүрэг 257.6 мянга, тэмээн сүрэг 58.1 мянга, хонь 1406.0 мянга, ямаа 2733.7 мянган толгой болж нийт мал сүргийн тоо таван төрөл дээрээ өсчээ.

Нийт мал сүргийн дотор адуу 4.1 хувь, үхэр 5.5 хувь, тэмээ 1.3 хувь, хонь 30.3 хувь, ямаа 58.8 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 0.5 пунктээр өсч, хониных 0.3 пункт, үхэр 0.1 пункт, тэмээнийх 0.1 пунктээр тус тус буурсан байна.

### Малын тоо 2019 онд

	МЯН.ТОЛ					
	Малын тоо		2019/2018		Нийт дүнд эзлэх хувь	
	2018	2019	Зөрүү	Хувь	2018	2019
<b>Бүгд</b>	<b>4249.5</b>	<b>4644.8</b>	<b>395.3</b>	<b>109.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Адуу	175.9	189.5	13.6	107.7	4.1	4.1
Үхэр	239.8	257.6	17.8	107.4	5.6	5.5
Тэмээ	57.4	58.1	0.7	101.2	1.4	1.3
Хонь	1297.5	1406.0	108.5	108.4	30.6	30.3
Ямаа	2478.9	2733.7	254.8	110.3	58.3	58.8

Манай аймаг улсад нийт малын тоогоор 4644.8 мянган толгой малтай зургаад, ямааны тоогоор 2733.7 мянган толгой ямаатай нэгдүгээрт, тэмээний тоогоор 58.1 мянган толгой тэмээтэй хоёрдугаарт, үхрээр 257.5 мянган толгой үхэртэй есдүгээрт, адуугаар 189.5 мянган толгой адуутай аравт, хониор 1406.0 мянган толгой хоньтой арваннэгдүгээрт орж байна.

Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 сумд Баацагаан 368.3 мянган толгой, Галуут 309.6 мянган толгой, Бууцагаан 303.1 мянган толгой, Бөмбөгөр 299.6 мянган толгой, Өлзийт 277.5 мянган толгой мал тус тус тоолуулжээ.

Аймгийн хэмжээнд 6 дугаар сарын мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээр оны эхний хээлтэгчийн 77.1 хувь буюу нийт 1517551 хээлтэгч мал төллөсөн ба гарсан төлийн 96.9 хувь буюу 1471048 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 9527, унага 37564, тугал 65007, хурга 496413, ишиг 862537 толгой тус тус бойжсон байна.

2020 оны 6 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 42021 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0.9 хувийг эзлэж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 88, адуу 3407, үхэр 2425, хонь 13745, ямаа 22356 толгой тус тус хорогджээ, мөн нийт хорогдсон малын 29.6 хувь буюу 12440 толгой хээлтэгч мал хорогдсон байна, төрлөөр нь харвал ингэ 15, гүү 1175, үнээ 654, эм хонь 4053, эм ямаа 6543 толгой хорогджээ.

Тариалсан талбайн 2020 оны 06 сарын мэдээгээр нийт 555.5 га тариалалт хийсэн байна. Тариалсан талбайг төрлөөр нь задлаж харвал төмс 204.6 га-д, тэжээлийн ургамал 236.8 га-д, хүнсний ногоо 109.8 га-д тус тус тариалжээ.

Тариалсан талбайг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 33.5 га буюу 19.6 хувиар өссөн, тэжээлийн ургамал 56.1 га буюу 19.2 хувиар, хүнсний ногоо 15.9 га буюу 14.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



### АЖ ҮЙЛДВЭР

2020 оны 8 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 27216.0 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7400.0 сая төгрөгөөр буюу 37.3 хувиар өссөн байна, ингэж өсөхөд нөлөөлсөн гол шалтгаан нь алт олборлолт, борлуулалт өссөнтэй холбоотой юм

#### Аж үйлдвэрийн борлуулалтын 2020 оны эхний 08 сарын гүйцэтгэл

Салбар	Нийт борлуулалт товчоо, салбараар				
	Аж үйлдвэрийн борлуулалт (мян.төг)				
	2019		2020		2020 2019
	VIII	I-VIII	VIII	I-VIII	I-VIII
Нийт дүн	3277758	19816326	4448109.7	27216065	137.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3132535	15777224	4223567.8	18229574	115.5
Боловсруулах аж үйлдвэр	52925.5	543831.9	134922.5	1022795.6	188.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	0	2441680.9	0	6875210.3	281.6

#### Аж үйлдвэрийн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2020 оны эхний 08 сарын гүйцэтгэл

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Биет хэмжээ				2020
		2019		2020		2019
		VIII*	I-VIII*	VIII*	I-VIII*	VIII*
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>						
Чулуун нүүрс	мян.тн	0	12	0	18.99	158.3
Алт	кг	28	152.9	33.559	151.525	99.1
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>						
Дулааны эрчим хүч	мян.Гкал	0	202.01	0	241.63	119.6
Хиам	тн	0.8	6.4	0.5	4.87	76.1
Боловсруулсан шингэн сүү	мян.л	0.26	3.493	0	2.359	67.5
Нарийн боов	тн	6.973	92.485	7.82	101.327	109.6
Талх	тн	10.03	104.889	10.25	122.687	116.9
Түгээсэн цэвэр ус	мян.м3	48.7	393.6	51.2	425.69	108.2



## **НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ**

Нийгмийн халамжийн сангаас эхний 8 сарын байдлаар нийт 9216.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгож үүнээс жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 2126 эхчүүдэд 39.2 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 7595 эхэд 988.2 сая төгрөг, алдар цолтой 25 ахмадад 31.7 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 3683 хүнд 592.9 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 293 хүнд 87.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



## **АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД**

Эхний 8 сард аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 567 болж өмнөх сараас 3.1 хувиар буурчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 303 буюу 53.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 80.2 хувь буюу 455 иргэн, 45 дээш насныхан 112 иргэн 19.8 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой иргэд 258 буюу 64.0 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой иргэд 65 буюу 11.5 хувь, дээд, магистр, докторын боловсролтой иргэд 139 буюу 24.5 хувийг тус тус эзлэж байна.

2020 оны 8 сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 695 иргэн үүнээс 353 эмэгтэй ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 443 иргэн буюу 63.7 хувь нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 351 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 51.6 хувь буюу 181 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 52, барилгын салбарт 14, Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 68, Худалдааны салбарт 48, санхүүгийн болон даатгалд 1, төрийн удирдлага болон албан журмын нийгмийн хамгаалалд 59, боловсролд 13, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 19, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагаа салбарт 13 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 8 сарын байдлаар 1065 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалд 185, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 32, Хөдөө аж ахуйн салбарт 225, Барилгын салбарт 176, Боловсролын салбарт 19, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 194, уул уурхай олборлолтын салбарт 46, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 25, боловсруулах үйлдвэрлэлд 88, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 12, бусад салбаруудад 0-9 ажлын байрны захиалга иржээ.



## ЭРҮҮЛ МЭНД

2020 оны 8 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 1373 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 25 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 91.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 8.7 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 8 сарын байдлаар 16 гарчээ.

8 сарын байдлаар нийт 882 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 68.7 байгааг өнгөрсөн оны мөн үе (120.0) тэй харьцуулахад буурч, сүрьеэгийн 2 нас баралт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад БЗДХ-ын тохиолдлын тоо буурч, нийт халдварт өвчний 81.2 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 716 тохиолдлын 16.6 хувийг заг хүйтэн, 67.9 хувийг трихомониаз, 15.5 хувийг тэмбүүгийн өвчлөл эзэлж байна

Аймгийн хэмжээнд эхний 8 сарын байдлаар нас баралтын 271 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 62 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 21.8 хувь нь эмнэлэгт нас барснаас 34.5 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 10943 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 24.0 хувийг алсын, 7.7 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага болон нийт дуудлаганд эзлэх алсын дуудлага нэмэгдэж, осол гэмтлийн дуудлага буурсан байна.



## ГЭМТ ХЭРЭГ

### 1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн талаар:

Тус цагдаагийн газар нь 2020 оны эхний 8 сард иргэд, аж ахуйн нэгжээс 3248 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаж шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 545 нэгжээр буюу 20,1 хувиар өссөн байна.



671 буюу 20,6%

- ✓ 384 буюу 57,2 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
- ✓ 230 буюу 34,2 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан.



2577 буюу 79,3%

- ✓ 1901 буюу 73,6 хувийг Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн
- ✓ 634 буюу 24,6 хувийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзсан
- ✓ 23 буюу 0,8 Харьяаллын дагуу шилжүүлсэн байна.


Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 249 буюу 42,4 хувийг 5 хоногт, 279 буюу 50,4 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2417

буюу 93.8 хувийг 5 хоногт, 131 буюу 5,5 хувийг 6 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

## 2. Бүртгэгдсэн гэмт хэрэг:


Аймгийн хэмжээнд энэ оны эхний 8 сард 329 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 112 нэгжээр буюу 25,4 хувиар буурсан.

Ааууиоїіāīđ àéіāā іū āуіò õу᠔āēēі āā᠔āēòāā᠔āā хил залгаа А᠔᠔āīāāē, аā᠔᠔āīāāē аймгаас 0,9-68 бага бол Аīāü-Аē᠔āē, Çāā᠔āī аймгаас 29,4-65,6 хувиар байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийн 138 буюу 41,9 хувь нь Баянхонгор суманд, 191 буюу 58 хувь нь бусад суманд үйлдэгдсэн ба Баянхонгор суманд үйдэгдсэн хэрэг 51,2 хувиар буурсан бол, бусад сумдад үйлдэгдсэн хэрэг 20,8 хувиар өссөн байна.

### Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




### Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 237 хэрэг бүртгэгдснээс 121 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 51,1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8 пунктээр өссөн байна.

#### Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 246 буюу 74,7 хувь нь хөнгөн ангилалын, 83 буюу 25,2 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



#### 2020 оны 8 сарын байдлаар /өссөн дүнгээр/



Хэргийн ангилал	2019 оны 8 сар	2020 оны 8 сар	Харьцуулалт
Хүнийг алах	4	3	-1 -25%
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	4	4	
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	134	76	-58 -43,2%
<b>Хүчиндэх</b>	<b>13</b>	<b>16</b>	<b>3 23%</b>
Хулгайлах	125	59	-66 -52,8%
Тээврийн хэрэгслийн хулгай	6	1	-5 -83,3%
<b>Мал хулгайлах</b>	<b>54</b>	<b>62</b>	<b>11 14,8%</b>
Дээрэм	2	1	-1 -50%
Залилах	23	17	-6 -26,6
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	1	1	

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	13	14	1	8%
Хүрээлэн буй орчны эсрэг	4	48	44	11 дахин
Бусад	43	28	-15	-34,8%

### Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа:

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 329 гэмт хэргээс 85 буюу 25,8 хувь нь гэр орон сууцанд, 24 буюу 7,2 хувь нь гудамж талбайд, 23 буюу 7 хувь нь олон нийтийн газар, 7 буюу 2,1 хувь нь төрийн байгууллагад, 5 буюу 1,5 хувь нь төрийн бус байгууллагад, 14 буюу 4,2 хувь нь авто замд, 6 буюу 1,8 хувь нь аж ахуйн нэгжид, 165 буюу 50,1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




### Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 258 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 нэгжээр буюу 11 хувиар буурсан бөгөөд үүнээс 26 буюу 10 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.

### Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 314 иргэн хохирч, үүнээс 91 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 36 нэгжээр буюу 28.3 хувиар, 11 хүн нас




барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4 нэгжээр буюу 26.6 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 864.1 сая төгрөгийн хохирол учирснаас 324.4 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 37.5 хувьтай байна.

## 2. Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймагт 2020 оны эхний 8 сард 20248 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3003 нэгжээр буюу 17.4 хувиар өссөн. **Ердийн журмаар /бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр/ 18273 зөрчлийг 371861.8 мянган төгрөгөөр, 1534 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 292040.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 441 зөрчлөөс 59 зөрчлийг 17750.0 мянган төгрөгөөр тус тус торгож, нийт 663901.8**



**мянган төгрөгийн торгууль ногдуулан ажилласан байна.**

279 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 46 нэгжээр буюу 19.7 хувиар, 416 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 3.5 хувиар тус тус өссөн байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
		Даваа гараг	3102 буюу 15.3 %
		Мягмар гараг	3209 буюу 15.8%
		Лхагва гараг	3353 буюу 16.6%
		Пүрэв гараг	3229 буюу 15.9%
		Баасан гараг	2885 буюу 14.2 %
		Бямба гараг	2329 буюу 11.5%
01-05 цагт	502 буюу 2.5%	Ням гараг	2141 буюу 10.6%

Энэ хугацаанд 672 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 151 нэгжээр буюу 18.3 хувиар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 24 буюу 3.6 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**